



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2018 оны 05 сарын 15 өдөр

Дугаар 219

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө худалдан авах
зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8 дахь хэсэг, "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 3.1, 3.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Хөгжлийн банкны харьяа "Ди Би Эм лизинг" хязгаарлагдмал хариуцлагатай компанийн албан ажлын хэрэгцээнд зориулан нийт 157,000,000.00 (нэг зуун тавин долоон сая) төгрөгөөр 1 ширхэг автомашиныг худалдан авахыг зөвшөөрч, автомашины техникийн үзүүлэлт, үнийн дээд хязгаарыг хавсралтаар баталсугай.

2.Хөгжлийн банкны харьяа "Ди Би Эм лизинг" хязгаарлагдмал хариуцлагатай компанийн гүйцэтгэх захирал О.Гэрэлмаад дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Үндсэн хөрөнгө худалдан авах ажлыг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зохион байгуулах;

2.2.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.3.Энэ тогтоолын биелэлтийг 2018 оны 2 дугаар улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3.Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т үүрэг болгосугай.

ДАРГА


ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН ХЭЛТСИЙН
ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Ц.НЯМ-ОСОР

Э.ЭРДЭНЭХИШИГ

0001777

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын
2018 оны 05 дугаар сарын 15-ны өдрийн
219 дугаар тогтоолын хавсралт



Хөгжлийн банкны харьяа "Ди Би Эм лизинг" хязгаарлагдмал
хариуцлагатай компанийн худалдан авах автомашин

Д/д	Хөрөнгийн нэр	Нэг бүрийн үнэ (төгрөг)	Тоо ширхэг	Худалдан авах үнийн дээд хязгаар (төгрөг)
1	Суудлын, хөдөлгүүрийн багтаамж 4500 cc хүртэл, суудлын тоо 7	157,000,000.00	1	157,000,000.00
	Нийт дүн		1	157,000,000.00 (нэг зуун тавин долоон сая)